



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Хэрлэн сумын 8 дугаар цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: ДОО-2020/45/СТА-ТШЗ**

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Чойбалсан хот 2020 он</p>	<p>Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас:70584203 Цахим хаяг: Bolortuulb@audit.gov.mn Аудитын менежер: В.Цэнгэлмаа Утас: 70584204 Цахим хаяг: Tsengelmaav@audit.gov.mn Аудитор: С.Энхбаатар Утас: 70584207 Цахим хаяг: Enkhbaatars@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТШЗ	Төсвийн шууд захирагч
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ДОА	Дорнод аймаг
БСШУЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам
БСУГ	Боловсрол соёл урлагийн газар



<b>Аудитын гэрчилгээ</b> .....	3
Аудитын тайлан .....	5
2.1. Оршил.....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	7
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	8
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	8
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....	8
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....	8
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан .....	9
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан .....	9
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	10
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	12
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	13
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	15



ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг  
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

АДА-02.14 № 74

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэрлэн сумын 8 дугаар цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Хэрлэн сумын 8 дугаар цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн Сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын Олон Улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хэрлэн сумын 8 дугаар цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

110520276

**Үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

## 2.1. Оршил

Хэрлэн сумын 8 дугаар цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг эрхлэгч Н.Алтанцэцэг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

## 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэрлэн сумын 8 дугаар цэцэрлэгийн 2019 оны 8 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэрлэн сумын 8 дугаар цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 05-наас 2020 оны 02 дугаар сарын 11-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 12-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, аудитор С.Энхбаатар хариуцаж хэрэгжүүлэв.

Хэрлэн сумын 8 дугаар цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 02 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

## 2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

## **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Хэрлэн сумын 8 дугаар цэцэрлэгийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Бага насны хүүхдийг өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжин, насан туршийн боловсролын суурь чадварыг эзэмшихэд дэмжин асрах, хамгаалах, хөгжүүлэх, сургалт, үйл ажиллагаагаар сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх”-д оршино.

Хэрлэн сумын 8 дугаар цэцэрлэгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Тус цэцэрлэг нь хоёр наснаас сургуульд элсэх хүртэлх насны хүүхдийг асрах, хамгаалах, хөгжүүлэх цогц үйл ажиллагаа бүхий сургалтын байгууллага мөн.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна.

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Хэрлэн сумын 8 дугаар цэцэрлэгийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Дорнод аймгийн 8 дугаар цэцэрлэг нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Acolous программ хангамж ашигладаг байна.

Хэрлэн сумын 8 дугаар цэцэрлэгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитаар Хэрлэн сумын 8 дугаар цэцэрлэгийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 11 эрсдэлтэй асуудалд 11 горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## **2.7. МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР**

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “ дунд ” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 552,992.8 мянган төгрөгөөс тооцон 11,059.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 11,879.4 мянган төгрөгөөр тооцсон нь 2019 онд зардлын гүйцэтгэл өссөнтэй холбоотой болно.

## 2.8. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Хэрлэн сумын 8 дугаар цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 48,590.2 мянган төгрөгөөр буюу 3.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	00.0	00.0	00.0
Авлага	00.0	00.0	00.0
Бараа материал	53,780.3	51,414.2	2,366.1
Үндсэн хөрөнгө	1,500,521.8	1,576,165.4	75,643.6
Үндсэн хөрөнгийн элэгдэл	-69,248.6	-93,935.9	-24,687.3
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,485,053.5</b>	<b>1,533,643.7</b>	<b>48,590.2</b>
Өр төлбөр	00.0	00.0	00.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,485,053.5	1,533,643.7	48,590.2
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1,485,053.5</b>	<b>1,533,643.7</b>	<b>48,590.2</b>

Бараа материалын дансны үлдэгдэл буурсан нь 2,409.9 мянган төгрөгийн аж ахуйн материал, 5,826.2 мянган төгрөгийн бусад хангамжийн материал, нийт 8,236.1 мянган төгрөгийн бараа материалыг акталснаас шалтгаалжээ. Энэ нь байгууллагын тооллогын комиссын санал, өмч хамгаалах зөвлөлийн дүгнэлтийг үндэслэсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өмнөх оноос өссөн нь барилга, байгууламжид улсын төсвийн хөрөнгөөр засвар хийгдсэн, аймаг, сумын төсвийн хөрөнгө оруулалтаар үнэ төлбөргүй хөрөнгө шилжүүлэн өгснөөс шалтгаалжээ. Хөрөнгө оруулалтаар 72,081.0 мянган төгрөгийн засварыг капиталжуулж, 5,700.0 мянган төгрөгийн үнэ төлбөргүй хүлээн авсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,533,643.7 мянган төгрөг болж 48,590.2 мянган төгрөгөөр өссөн нь үйл ажиллагааны үр дүн нэмэгдсэнээс шалтгаалжээ. Энэ нь хөрөнгө оруулалт хийгдсэнтэй холбоотой байна.

## 2.9. ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 8 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй. Тус цэцэрлэгийн хувьд орлогын төлөвлөгөө байхгүй байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 559,443.6 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 559,443.6 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 524,389.4 мянган төгрөгийг улсын төсвөөс, 35,054,2 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөгджээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 556,271.2 мянган төгрөг буюу 99,4 хувьтай байгаа нь тайлант хугацаанд төсвийн хуваарийн дагуу зардлыг зарцуулсантай холбоотой байна.

**Нэмэлт төсөв:** Тендерийн баримт бичгийн орлогоор 347.0 мянган төгрөгийн нэмэлт төсөв бүрдүүлж, бичиг хэргийн зардалд бүрэн зарцуулсан байна.

#### **2.10. АУДИТААР ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН**

Аудитыг төлөвлөх үе шатанд 11 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 11 эрсдэл тодорхойлж, нийт 11 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 16,139.5 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 9,254.7 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгч менежментийн захидалд тусган, 6,884.8 мянган төгрөгийн алдаанд залруулга хийлгэлээ.

#### **2.11. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ**

Байхгүй.

#### **2.13. ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ**

Хэрлэн сумын 8 дугаар цэцэрлэг Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

#### **2.12. ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН АКТ, АЛБАН ШААРДЛАГА, ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 0.2 сая төгрөгийн 1 актыг бүрэн барагдуулж, 1 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

#### **2.13. ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ**

Бид Хэрлэн сумын 8 дугаар цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Дорнод аймгийн Хэрлэн сумын 8 дугаар цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дугаар зүйл, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

*1. Худалдан авалтын талаар:*

- 1.1. Илрүүлэлт: Тайлант хугацаанд хийсэн нийт худалдан авалтын 9.5 хувь буюу 9,254.7 мянган төгрөгийн Е-баримтыг анхан шатны баримтад хавсаргаагүй байна.
- 1.2. Эрсдэл: Төсвийн хөрөнгө зориулалт бусаар зарцуулагдах.
- 1.3. Өгсөн зөвлөмж: Худалдан авалтын баримтад е-баримтыг хавсаргаж байх.
- 1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Өгсөн зөвлөмжийн дагуу ажиллах болно

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>53,780,313.80</b>	<b>51,414,181.80</b>
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	53,780,313.80	51,414,181.80
354	<b>Хангамжийн материал</b>	53,780,313.80	51,414,181.80
35410	Бичиг хэргийн материал	3,257,390.00	3,300,790.00
35420	Аж ахуйн материал	8,411,875.00	6,001,975.00
35470	Бусад хангамжийн материал	42,111,048.80	42,111,416.80
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,431,273,184.63</b>	<b>1,482,229,487.15</b>
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,431,273,184.63	1,482,229,487.15
391	Газар	00.00	00.00
392	<b>Биет хөрөнгө</b>	1,203,773,184.63	1,254,729,487.15
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,151,014,038.00	1,223,095,022.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-19,248,111.84
39203	Авто-тээврийн хэрэгсэл	00.00	00.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	00.00	00.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	45,338,873.33	48,255,073.33
39206	Хуримтлагдсан элэгдэл	-37,210,496.19	-39,553,758.31
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	27,839,018.90	28,485,418.90
39208	Хуримтлагдсан элэгдэл	-20,681,909.78	-20,737,596.54
39214	Бусад үндсэн хөрөнгө	48,389,892.00	48,389,892.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-10,916,231.63	-13,956,452.39
393	<b>Биет бус хөрөнгө</b>	227,500,000.00	227,500,000.00
39301	Програм хангамж	440,000.00	440,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-440,000.00	-440,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	227,500,000.00	227,500,000.00
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,485,053,498.43</b>	<b>1,533,643,668.95</b>
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,485,053,498.43</b>	<b>1,533,643,668.95</b>
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,485,053,498.43	1,533,643,668.95
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	554,954,652.20	554,954,652.20
51101	Өмч: - төрийн	554,954,652.20	554,954,652.20
512	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	-83,807,322.50	-35,217,151.98
51210	Өмнөх үеийн үр дүн	-83,807,322.50	-83,807,322.50
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	48,590,170.52
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,013,906,168.73	1,013,906,168.73
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,485,053,498.43</b>	<b>1,533,643,668.95</b>

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>557,122,200.00</b>	<b>642,562,284.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>22,423,000.00</b>	<b>82,771,684.00</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	00.00	4,990,700.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	4,990,700.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	4,990,700.00
121	<b>Хөрөнгийн орлого</b>	22,423,000.00	77,780,984.00

121001	Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого	22,423,000.00	77,780,984.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>30,690,100.00</b>	<b>35,401,200.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	27,890,100.00	00.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	27,890,100.00	00.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	504,009,100.00	524,389,400.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	2,800,000.00	347,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,500,000.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	300,000.00	347,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	00.00	35,054,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	35,054,200.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>552,992,831.45</b>	<b>593,972,113.48</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>552,992,831.45</b>	<b>593,972,113.48</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	534,693,351.45	590,299,698.48
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	322,776,315.00	368,308,600.00
210101	Үндсэн цалин	274,970,429.00	333,688,238.00
210102	Нэмэгдэл	19,176,180.00	10,336,460.00
210104	Урамшуулал	28,629,706.00	24,283,902.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	39,392,279.00	45,956,324.00
210201	Тэтгэврийн даатгал	26,501,589.00	25,278,849.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,222,671.00	9,572,604.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,578,138.00	2,961,266.00
210204	Ажилгүйдлийн даатгал	644,535.00	740,290.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,445,346.00	7,403,315.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	32,297,136.00	30,675,545.00
210301	Гэрэл, цахилгаан	8,945,970.00	8,861,306.00
210302	Түлш, халаалт	14,288,680.00	11,987,018.00
210303	Цэвэр, бохир ус	9,062,486.00	9,827,221.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	3,341,410.00	10,936,998.00
210401	Бичиг хэрэг	995,500.00	1,339,998.00
210402	Тээвэр, шатахуун	1,040,300.00	450,250.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	392,610.00	156,613.00
210404	Ном, хэвлэл	00.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	100,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	913,000.00	653,900.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	00.00	00.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	8,236,137.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	110,197,580.00	102,811,050.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	218,205.00	231,900.00
210502	Хоол, хүнс	109,374,375.00	101,889,150.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	605,000.00	690,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2,000,000.00	1,300,000.00
210604	Урсгал засвар	2,000,000.00	1,300,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	250,000.00	146,000.00
210702	Дотоод албан томилолт	250,000.00	146,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	933,000.00	1,410,000.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	933,000.00	1,230,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	180,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>23,505,631.45</b>	<b>28,755,181.48</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	500,000.00	500,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	769,724.00	1,430,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	22,235,907.45	26,824,681.48
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>18,299,480.00</b>	<b>3,672,415.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>18,296,600.00</b>	<b>500,000.00</b>
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	17,796,600.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	500,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>2,880.00</b>	<b>3,172,415.00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,880.00	3,172,415.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>4,129,368.55</u></b>	<b><u>48,590,170.52</u></b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>4,129,368.55</u></b>	<b><u>48,590,170.52</u></b>

#### 4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>534,699,200.00</u></b>	<b><u>559,790,600.00</u></b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>534,699,200.00</b>	<b>559,790,600.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	27,890,100.00	00.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	27,890,100.00	00.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	504,009,100.00	524,389,400.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	2,800,000.00	347,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,500,000.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	300,000.00	347,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	00.00	35,054,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	35,054,200.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>534,699,200.00</u></b>	<b><u>559,790,600.00</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>534,699,200.00</b>	<b>559,790,600.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>516,399,720.00</b>	<b>556,118,185.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>324,451,815.00</b>	<b>368,308,600.00</b>
210101	Үндсэн цалин	278,990,341.00	333,688,258.00
210102	Нэмэгдэл	16,831,768.00	10,336,440.00
210104	Урамшуулал	28,629,706.00	24,283,902.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>39,392,279.00</b>	<b>45,956,324.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	27,393,779.00	25,278,849.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,748,900.00	9,572,604.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,650,400.00	2,961,266.00
210204	Ажилгүйдлийн даатгал	599,900.00	740,290.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,999,300.00	7,403,315.00

<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	32,502,136.00	30,675,545.00
210301	Гэрэл, цахилгаан	8,945,970.00	8,861,306.00
210302	Түлш, халаалт	14,288,680.00	11,987,018.00
210303	Цэвэр, бохир ус	9,267,486.00	9,827,221.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	5,547,615.00	3,649,066.00
210401	Бичиг хэрэг	604,000.00	1,282,122.00
210402	Тээвэр, шатахуун	1,040,300.00	450,250.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	467,610.00	156,613.00
210404	Ном, хэвлэл	00.00	170,176.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	100,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,435,705.00	1,489,805.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	00.00	00.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	110,047,875.00	102,809,150.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	268,500.00	231,900.00
210502	Хоол, хүнс	109,374,375.00	101,889,150.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	405,000.00	688,100.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2,000,000.00	1,300,000.00
210604	Урсгал засвар	2,000,000.00	1,300,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	250,000.00	146,000.00
210702	Дотоод албан томилолт	250,000.00	146,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	858,000.00	1,410,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	858,000.00	1,230,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	180,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	1,350,000.00	1,863,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	500,000.00	500,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	850,000.00	1,363,500.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>18,299,480.00</b>	<b>3,672,415.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	18,296,600.00	500,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	17,796,600.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	500,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	2,880.00	3,172,415.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,880.00	3,172,415.00
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	00.00	00.00
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	00.00	00.00
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	00.00	00.00

#### 4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	/ төгрөгөөр /
						Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	327,454,652.20	374,102,577.10	-86,774,314.17	00.00	614,782,915.13
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>327,454,652.20</b>	<b>374,102,577.10</b>	<b>-86,774,314.17</b>	<b>00.00</b>	<b>614,782,915.13</b>
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	229,907,338.00	00.00	2,966,991.67	00.00	232,874,329.67
C08	<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>554,954,652.20</b>	<b>1,013,906,168.73</b>	<b>-83,807,322.50</b>	<b>00.00</b>	<b>1,485,053,498.43</b>
D01	<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>554,954,652.20</b>	<b>1,013,906,168.73</b>	<b>-83,807,322.50</b>	<b>00.00</b>	<b>1,485,053,498.43</b>
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>554,954,652.20</b>	<b>1,013,906,168.73</b>	<b>-83,807,322.50</b>	<b>00.00</b>	<b>1,485,053,498.43</b>
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	48,590,170.52	00.00	48,590,170.52
D09	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>554,954,652.20</b>	<b>1,013,906,168.73</b>	<b>-35,217,151.98</b>	<b>00.00</b>	<b>1,533,643,668.95</b>

#### 4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	559,443,600.00	559,443,600.00
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	559,443,600.00	559,443,600.00
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	558,943,600.00	555,771,185.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	368,308,600.00	368,308,600.00
210101	Үндсэн цалин	335,436,600.00	333,688,258.00
210102	Нэмэгдэл	10,675,300.00	10,336,440.00
210104	Урамшуулал	22,196,700.00	24,283,902.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	46,038,800.00	45,956,324.00
210201	Тэтгэврийн даатгал	31,306,200.00	25,278,849.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,683,300.00	9,572,604.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,946,400.00	2,961,266.00
210204	Ажилгүйдлийн даатгал	736,600.00	740,290.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,366,300.00	7,403,315.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	33,754,200.00	30,675,545.00
210301	Гэрэл, цахилгаан	9,650,000.00	8,861,306.00
210302	Түлш, халаалт	14,254,200.00	11,987,018.00

210303	Цэвэр, бохир ус	9,850,000.00	9,827,221.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>3,302,300.00</b>	<b>3,302,066.00</b>
210401	Бичиг хэрэг	500,000.00	935,122.00
210402	Тээвэр, шатахуун	250,500.00	450,250.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	300,000.00	156,613.00
210404	Ном, хэвлэл	150,000.00	170,176.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	100,000.00	100,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,001,800.00	1,489,805.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>102,809,200.00</b>	<b>102,809,150.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	170,000.00	231,900.00
210502	Хоол, хүнс	101,889,200.00	101,889,150.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	750,000.00	688,100.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,300,000.00</b>	<b>1,300,000.00</b>
210604	Урсгал засвар	1,300,000.00	1,300,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>150,000.00</b>	<b>146,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	150,000.00	146,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,410,000.00</b>	<b>1,410,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,230,000.00	1,230,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180,000.00	180,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1870500.00</b>	<b>1863500.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	500,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,870,500.00	1,363,500.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>500000.00</b>	<b>3672415.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>500,000.00</b>	<b>3,672,415.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	500,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>00.00</b>	<b>559,443,600.00</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>00.00</b>	<b>524,389,400.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	00.00	524,389,400.00
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>00.00</b>	<b>35,054,200.00</b>
132001	Орон нутгийн төсвөөс	00.00	35,054,200.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>41.00</b>	<b>41.00</b>
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	33.00	33.00
620003	Үйлчлэх ажилтан	07.00	07.00
620004	Гэрээт ажилтан	00.00	00.00